



# МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

# СОЁМБОМ ЭДЭЭ

199 /199/ 2021.12.13

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Түүхэнд энэ өдөр

1961 он.

## БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР ЭЛЧИН САЙД ЗАФЕР АТАШИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Зафер Аташийг хүлээн авч уулзлаа.

Уулзалтаар хоёр улсын дипломат харилцаа, тэр дундаа батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны өнөөгийн түвшин, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, үйл ажиллагааг дүгнэж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн талаар санал солилцлоо.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр БНТУ-ын Элчин сайд Зафер Аташийг үүрэгт ажилдаа томилогдсон явдалд баяр хүргэж, амжилт хүссэний зэрэгцээ БНТУ-д хийсэн ажлын айлчлал, тус улсын Үндэсний батлан хамгаалахын сайд Хулуси Акартай хийсэн хоёр талын уулзалт, эдийн засаг, худалдааны

Монгол, Туркийн Засгийн газар хоорондын хамтарсан хорооны IX хуралдаан үр дүнтэй явагдсаныг онцлов. Цаашид хэрэгжилтийг хангах талаар Элчин сайдын яамтай идэвхтэй хамтарч ажиллахаа илэрхийллээ.

Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Зафер Аташ Батлан хамгаалахын сайдтай уулзсандаа сэтгэл өндөр байгаа бөгөөд цаг гарган хүлээн авсанд талархлаа илэрхийлэв. Тэрээр цаашид хоёр орны харилцаа, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхээс гадна эдийн засаг, худалдааны Монгол, Туркийн Засгийн газар хоорондын хамтарсан хорооны хуралдааны протоколд тусгагдсан үйл ажиллагааны хэрэгжилтэд онцгой анхааран ажиллахаа мэдэгдлээ.



АЦХЭЯ-ны сайдын тушаалаар барилгын газрыг өргөтгөн, барилга инженерийн ерөнхий газар болж, АЦХЭЯ-ны орлогч сайд бөгөөд инженерийн ерөнхий газрын даргаар Д.Гэсэржавыг томилж, хурандаа цол олгов.

### ЦАГ АГААР

#### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-10	-27

#### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	24

### ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,844.0	2,855.0
EUR	3,182.0	3,253.0
CNY	446.00	450.50
RUB	37.80	39.80
JPY	24.75	25.39
KRW	2.34	2.47

### ЗУРХАЙ

2021.12.13 ДАВАА ГАРАГ  
/БИЛГИЙН ТООЛЛЫН 10/

ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САРЫН ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:

Эрч хүч ихэснэ  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
08.33-16.59

Барилдлага:  
Рашаан

Шүтэн барилдлага:  
Хурьцахуй

Суудал:

Огторгуй

Энэ өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамырыг сэргээх, лус тахиx, мал худалдан авах, мал түгээх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Цөөрөм байгуулах, сахил санваар авах, хануур, төөнүүр хийлгэх, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар явар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрч, хүч нэмнэ.

Үс засуулбал эрч, хүч нэмнэ

## “АСАЖ ДҮҮЛСЭН ОН ЖИЛҮҮД”-ИЙН ТҮҮХИЙГ ДУУРЬСГАЛАА



ЦДБЭЧ-ын 89 жилийн ойн энэ өдөр чуулгын “Бүжгийн алба” үүсэж хөгжсөний түүхт 80 жилийн ойд зориулсан “Асаж дүүлсэн он жилүүд” хүндэтгэлийн тоглолт үзэгч түмнийхээ мэлмийг баясгалаа. Түүхт ойн хүндэтгэлийн тоглолтын эхэнд ажил амжилтаараа хамт олноо манлайлсан уран бүтээлчид, ажилтнуудад салбарын болон бусад салбарын шагналыг БХЯ-ны ТЗУГ-ын Хүний нөөцийн бодлогын ахлах мэргэжилтэн хурандаа Д.Содномдаржаа, БХЯ-ны ТЗУГ-ын Нийгмийн хамгаалал, шагнал урамшуулал хариуцсан мэргэжилтэн дэд хурандаа Д.Мөнхзаяа, ЦДБЭЧ-ын дарга хурандаа Г.Золзаяа, Чуулгын даргын орлогч-Уран сайхны удирдагч хошууч Л.Баттөр, чуулгын ахлагч Тэргүүн ахлагч Ө.Сэргэлэн, Захиргаа үзвэр үйлчилгээний хэлтсийн дарга дэд хурандаа А.Дондов тэргүүтэй удирдлагууд гардуулан өгч баяр хүргэсэн юм.

Монгол цэргийн бүжгийн гайхамшиг, омогшил, онцлогийг илтгэн харуулж он цагийн хэлхээнд шигшигдсэн шилдэг бүтээлийн дээжсээ толилуулсан энэхүү тоглолтод ЦДБЭЧ-ын үе үеийн бүжигчид оролцож, олон алдартан гавьяатнууд нэгэн дор хуран цугласан үдэш байлаа. ЦДБЭЧ-ын “Бүжгийн алба”-ны 80 жилийн ойн ажил, арга хэмжээнүүд, тоглолт уран бүтээлүүдэд ЦДБЭЧ, Монгол цэргийн бүжгийн “Гэрэгэ” холбоо, “Урлаг маркет” групп хамтран ажиллаж ийнхүү энэ өдөр үзэгчдэд хүндэтгэлийн тоглолтоо өргөн барьсан нь бүжгийн урлагт бахдан бишрэгч, шимтэн сонирхогч хэн бүхний мэлмий, сонорыг мялаан, халуун алга ташилтаар дүүрэн үдэш боллоо.

### МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 374.040 +296	ВАКЦИНЖУУЛАЛТ 2,153,968 +560	НАС БАРСАН 1,947 +3
----------------------------------	---------------------------------	------------------------

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 6684 +111	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 127	ЭДГЭРСЭН 6429
------------------------------	----------------------------	------------------

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 270,412,730
Эдгэрсэн Нийт: 243,084,407
Нас барсан Нийт: 5,321,729

цаг үе, үйл явдал

# Г.К.ЖУКОВЫН МЭНДЭЛСНИЙ 125 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН БОЛОВСРОЛЫН АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор баталсан “Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр, Боловсрол, Соёл шинжлэх ухаан, спортын сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан тогтоолууд болон Үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний дэд хөтөлбөр, Монгол цэргийн музейн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 72 дугаар дунд сургуулийн 4 дүгээр ангийн сурагчдын дунд “Цэргийн албыг цэргийн музейгээс” танин

мэдэхүй боловсролын ажлыг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабтай хамтран зохион байгууллаа.

Тус боловсролын ажлын I хэсэгт ЗХУ-ын хошой баатар, БНМАУ-ын баатар, Армийн генерал И.А.Плиевын нэрэмжит 49 дүгээр дунд сургуулийн 7 дугаар ангийн сурагчдын ЗХУ-ын 4 удаагийн баатар, БНМАУ-ын баатар, ЗХУ-ын маршал Г.К.Жуковын мэндэлсний 125 жилийн ойг тохиолдуулан бүтээсэн “Зовох цагт нөхрийн чанар танигдана” үлгэрийн номоор сэдэвчилсэн жүжигчилсэн тоглолтыг үзүүлэн, үлгэрийн номын баатруудын талаар

асуулт тавьж, хэрхэн зөв ойлгосон тухай зураг зуруулсан юм.

Харин боловсролын ажлын II хэсэгт 1944, 1980-аад оны үеийн цэргийн алба хаагчдын өмсөж байсан дүрэмт хувцасны загварыг сурагчдад өмсүүлж, дурсгалын зураг татуулав.

Мөн энэ үеэр Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын сургалтын офицер ахмад Н.Лхамжав дүрэмт хувцсыг хэрхэн зөв өмсөх болон хугацаат цэргийн албаны талаар яриа таниулга хийсэн нь багачуудын сонирхлыг татаж цэргийн албаны талаар бодит мэдээлэл өглөө.




## ГЭРЭЛ ЗУРАГ НЭГ АГШИН

Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчид 30 км-ийн явган маршаар алхаж байгаа нь.

2021.12 дугаар сарын 03



## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ЭЭЛТЭЙ МУЗЕЙ



НҮБ-аас жил бүрийн 12 дугаар сарын 3-ны өдрийг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр” болгон зарласан байдаг.

Хүний эрхийг дээдэлсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ тэгш боломжоор хангадаг хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх талаар төр засгаас шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсээр байна. Энэ хүрээнд Монгол цэргийн музей хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэхгээ хүртээмжтэй хүргэх зорилгоор тайлбараа дохионы хэлээр бэлтгэн брайл үсгэн тайлбарт ном бэлтгэн үйлчилж байгаагийн дээр Ерөнхий боловсролын 116, 29 дүгээр сургууль, “Сэргээн засах төв” зэрэг байгууллагуудтай хамтран ажилладаг юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд соёлын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэж байгаа Монгол цэргийн музейг ХНХЯ-наас 2014 онд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй музей”-гээр тодруулж батламж гардуулсан юм.

Бид музейн орчныг хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх боломж бүхий зам, бие засах газар зэргийг тохижуулсан бөгөөд үзүүллийн танхим, дүрст тайлбар бүртээ дохионы хэлний орчуулгатай тайлбар байршуулж, харааны бэрхшээлтэй үзэгчдэд хүрч мэдрэх боломж бүхий үзмэрүүдийг тусгайлан бэлтгэн брайл үсгэн тайлбарыг ашиглаж байгаа бөгөөд цаашид технологийн орчин үеийн шийдлийг ашиглахаар зорьж байна.

## АНУ УКРАИНД ЗЭВСЭГ ТЕХНИК ШИНЭЭР НИЙЛҮҮЛЭХЭЭ ТОДОРХОЙГУЙ ХУГАЦААГААР ХОЙШЛУУЛАВ



Ж.Байдены засаг захиргаа Украинд цэргийн тусламж үзүүлэх болзол, нөхцөлийн тухай асуудлаар шинэ шийдвэр гаргасныг Украины тал гайхширан хүлээн авав. АНУ-ын хэвлэлд гарч буй мэдээллүүдээс үзэхэд АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Байден Украинд үзүүлэх цэрэг-техникийн тусламж, нийлүүлэлтээ түр зогсоох шийдвэр гаргасан байна. Саяхан гарсан мэдээллээс үзэхэд, АНУ Украинд 200 сая ам.долларын багц бүхий цэргийн зэвсэг техник нийлүүлэхээр ирэх оны төсөвтөө суулгасан байсан. Украины Зэвсэгт хүчний хэрэгцээ шаардлагад зориулан дээрх зэвсэг техникийг нийлүүлэхэд бэлэн болсон гэдгийг АНУ-ын тал цохон тэмдэглэж байв. Гэсэн хэдий ч ОХУ-ын

Ерөнхийлөгч В.Путин, АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Байден нар виртуал уулзалт хийсний дараахан Ж.Байдены засаг захиргаа тэдгээрийг нийлүүлэх хугацааг тодорхойгүй хугацаагаар хойшлуулах шийдвэр гаргасан байна. АНУ дээрх шийдвэрийг янз бүрээр тайлбарлаж байгаа бөгөөд албан ёсны тайлбар мэдэгдэл хараахан гараагүй байна. Тухайлбал “АНУ Украинд 200 сая ам.долларын зэвсэг техникийг шилжүүлэхийг түр зогсоосон нь Путин Байдены анхааруулгыг сонсоод одоог хүртэл Украин руу довтлохгүй байгаа” гэж Америкийн хэвлэлээр бичигдэж буй бол бусад эх сурвалжуудад “АНУ-ын засаг захиргаа Украин руу 200 сая ам.долларын цэрэг-техникийн тусламж

илгээхээ хойшлуулсан, учир нь тэд илүү том багц бэлтгэж байна” гэх зэргээр олон янзын тайлбар хөвөрч байна. (Мэдээж шийдвэрийн тухай албан ёсны тайлбар, мэдэгдлийг хүлээх нь зүйтэй) Харин Украины тал АНУ-ын шийдвэрт эргэлзэж, гайхаж хүлээн авч байна. Тодруулбал, “Украины хувьд маш хүнд үед тусламжийг хойшлуулсан” гэж тус улсын хэвлэлүүдээр бичигдэж байгаа юм. Хэрэв Украин ОХУ хооронд цэргийн сэргөлдөөн гарвал Украинд зөвхөн өөртөө найдах хэрэг гарч магадгүй гэж зарим шинжээчид ярьж эхлэв. Хамгийн сүүлд Украины тал АНУ-аас “Жавелин” танк эсэргүүцэгч пуужингийн цогцолбор, мөн зэвсэглэлээс ақтлагдсан хоёр нэгж эргүүлэн завь хүлээн авсан байдаг.

Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ  
Батлан хамгаалах яам  
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС  
“Соёмбо” сонин  
“Дуулга” студи

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.  
\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.  
\* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018  
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)